



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 24

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 685,194 (Зургаан зуун наян таван мянга нэг зуун ерэн дөрөв) төгрөгийн балансын үнэтэй, 288,494,07 (Хоёр зуун наян найман мянга дөрвөн зуун ерэн дөрөв) төгрөгийн үлдэх өртөгтэй хоёр нэр төрлийн хөрөнгийг хавсралтад заасны дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Долгоржав), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
24 дүгээр тогтоолын хавсралт



Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн
актлах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	
			хэмжих нэгж	биет хэмжээ						
1	Аж ахуйн склад /нүүрсний/	агуулах	ш		2022.01.01	1	433,944	166,345,20	267,598,8	
2	Нийтийн эзэмшлийн 6 настны нойл	нойл	ш		2008.09.01	1	251,250	230,354,73	20,895,27	
Нийт дүн								685,194 (зургаан зуун наян таван мянга нэг зуун ерэн дөрөв) төгрөг	396,699,93 (гурван зуун ерэн зургаан мянга зургаан зуун ерэн есөн төгрөг ерэн гурван мөнгө) төгрөг	288,494,07 (хоёр зуун наян найман мянга дөрвөн зуун ерэн дөрөв) төгрөг